

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020.40

Мод, сөөгний суулгац арчлах	MNS 6258-2 : 2011
Caring of tree and brush seedlings	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

## 1. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь хот, суурин газрын нийтийн эзэмшил, хязгаарлагдмал хэрэгцээний болон тусгай зориулалтын ногоон байгууламжийн талбайн мод, сөөг, ургамлан хашлаганд суулгасан суулгацыг арчлах, хамгаалахад хамаарна.

## 2. Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг иш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас иш татаж хэрэглэнэ.

- ГОСТ 25769:83, Ногоон байгууламжин дахь шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шардлага,
- ГОСТ 26869:86, Чимэглэлийн сөөгний суулгац. Техникийн шаардлага,
- ГОСТ 24909:81, Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага.

## 3. Нэр томъёо ба тодорхойлолт

### 3.1

#### Мод

Титэм бүхий гол иштэй модлог ургамал,

### 3.2

#### Сөөг

Гол ишгүй, үндэсний хүзүүнээс дээш адил хэмжээний олон иштэй 5 метр хүртэл өндөр ургадаг модлог ургамал.

### 3.3

#### Тарьц

Мод үржүүлгийн газарт үр болон мөчрөөр ургуулсан 1-ээс 2 настай модлог ургамал,

### 3.4

#### Суулгац

Бойжуулгын талбайд шилжүүлэн суулгаж ургуулан 2-оос дээш настай модлог ургамал,

### 3.5

#### Таналт

Мод, сөөгний титмийн жигд өсөлтийг дэмжих арчилгаа,

**3.6**

**Хэлбэржүүлэлт**

Мод, сөөгний суулгацын титмийн хэсэгт хийх арчилгаа.

**4. Суулгацыг арчлах**


**4.1** Суулгасан мод, сөөг цаашид амьдрах эсэх нь гагцхүү арчлалт хамгаалалтаас шалтгаалдаг учир услах, бордох, хөл газрын ургамлыг устгах, хөрс сийрүүлэх, титмийн хэлбэржүүлэлт, таналт тайралт хийх зэрэг арчилгааг цаг хугацаанд нь тогтмол хийнэ.

**4.2** Суулгацыг суулгах үед хөрсийг ханатал услах нь үндсийг эрчимтэй хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ.

**4.3** Усалгааг суулгацыг суулгасны эхний сард 3-аас 5 хоногт 1 удаа, дараагийн саруудад 5-аас 7 хоногт 1 удаа 60-аас 80 л усаар услана. Хоёр дахь жилээс эхлэн 5-аас 7 дугаар саруудад 7 хоногт 1 удаа, дараагийн саруудад 10 хоногт 1 удаа хөрсний чийгийн багтаамж 50 %-иас доошгүй байхаар усална.

Ургамлан хашлаганд тарьсан сөөгний уртааш метр тутамд 30-аас 40 л усаар усална. Мод, сөөг тарьсан эхний жил усалгаа хийсний дараа үндэсний хүзүү орчмын хөрсийг нягтруулна.

Хавар 4 дүгээр сар, намар 10 дугаар сард цэнэг усалгаа хийнэ.



1-р зураг. Усалгааг тогоо болон шангаар хийх байдал

**4.4** Модны өсөлтийг сайжруулахын тулд мод, сөөгний орчныг бордсны дараа усална.


**4.5** Тарьсан модны орчин тойрны хөл газрын ургамлыг цэвэрлэж, хөрсийг сийрэгжүүлнэ. Хөл газрын ургамлыг мод, сөөгний суулгац тарьсан эхний 3 жилд ургалтын хугацаанд 6-аас 8 дугаар саруудад тус бүр 1 удаа цэвэрлэнэ. Цаашид жилд 1-ээс 2 удаа хийнэ.

**4.6** Мод сөөгний титмийн жигд өсөлт, гадаад үзэмжийг харгалзан хавар эрт, намар орой титмийг хэлбэржүүлж засаж танах, үхэж, хатсан мөчрөөс цэвэрлэж, шинээр салаалсан хажуугийн мөчрийг тайрч, иш гаргаж хэлбэржүүлэх, залуужуулах, цэвэрлэгээний огтлолтуудыг хийнэ.


4.7 Хэлбэржүүлэх **тайралтаар** удаан ургалттай модны сүүлийн жилийн өсөлтийн 25-аас 50%-ийг, түргэн ургалттай модны өсөлтийн 70-аас 80%-ийг тайрна.

4.8 Залуужуулах **тайралтаар** өсөлт нь зогсонги байдалд орсон, хөгширч муудсан, үхсэн мөчрүүдэд, найлзуур нь үзүүрээсээ хатаж байгаа мод, сөөгөнд хийнэ.

4.9 Цэвэрлэгээний **тайралтаар** мод, сөөгөнд өвчин, хортны голомт үүссэн, гэмтсэн, буруу ургалттай, хатаж хуурайшсан мөчир, найлзуурыг цэвэрлэх зорилгоор хийнэ.



2-р зураг. Бөөрөнхий тайралт



3-р зураг. Гурвалжин тайралт

Тайлбар 1: Мод, сөөгийг хэлбэржүүлэх тайралт нь гурвалжин, бөөрөнхий, дөрвөлжин, баганан, гэх мэт олон янз байна.

## 5. Суулгацыг хамгаалах

5.1 Тарьсан мод, сөөгний суулгац, зүлгийг хүн, машин, малын хөлд гишгэгдэхээс хамгаалж хайс хийж, явган хүний зам гаргасан байна.

5.2 Газар хөлдөхөөс өмнө тарьсан мод, сөөгийг ханатал услаж, суулгацыг хөлдөхөөс хамгаалж цас тогтооно. Шаардлагатай бол мод, сөөгний суулгацыг зориулалтын материалаар хучиж өвөлжүүлнэ.




4-р зураг. Хучиж өвөлжүүлэх байдал


**5.3** Мод, сөөгний гэмтсэн хэсгийг зэсийн байван ( 1 0 л усанд 300 г-аас ихгүй хийж) ариутгаж, гадна талаас нь будах буюу хатуу цаасаар хамгаалж бооно.

**5.4** Хугарсан, гэмтсэн, мөчир, найлзуурыг хурц хутга, мөчир тайрагч хайчаар эгц огтолж тэр хэсэгт тосон будаг түрхэж хамгаалсан байна.

**5.5** Модны ишийг нарны төөнөлтөнд түлэгдэж гэмтэх, шавьж, өдөр, шөнийн температурын хэт хэлбэлзэлээс хамгаалах зорилгоор шохойн уусмалаар будна.



г. Мөчрийн тайралт а - зөв, б - буруу



6-р зураг. Мөчир тайрч, будах

**ТӨГСӨВ.**